

BudgeTone-200/201 SIP Phone тохируулах гарын авлага

1.Харагдах байдал

BT-200/201 утаснууд нь гурван талаасаа дараах байдлаар харагдана.



2. Оролтын портууд




LAN	Интернэтэд холбогдох порт (RJ-45 толгойтой UTP кабель орно)
PC	Компьютерт холбогдох порт (RJ-45 толгойтой UTP кабель орно. BT-201 утсанд энэ порт байхгүй)
Power	Тэжээлийн оролт (5V тогтмол хүчдэлийн (DC) порт. Өөр төрлийн тэжээлийн адаптер ашиглавал төхөөрөмж гэмтэж болохыг анхаарна уу!)
HEADSET	Чихэвчний оролт (2.5 mm)

3. Тохиргоо хийх

3.1 Утсаар дамжуулж холбох (зөвхөн BT200 боломжтой)


IP phone болон сүлжээний кабель, компьютероо доорхи зурагт үзүүлсэн байдлаар холбоно.

- Гаднаас орж ирсэн интернэтийн кабелиа BT200 утасны LAN гэсэн портонд холбоно.
- Компьютероо UTP кабель ашиглан (дагалдаж ирдэг цэнхэр кабель) BT200 утасны PC гэсэн портонд холбоно.



3.2 Шууд холбох (BT200, BT201 аль алинд нь боломжтой)

Эсвэл салаалагч буюу switch –дээ илүү кабельтай бол дараахь маягаар холбож болно. Утасны LAN портонд кабелиа залгана. Ингэснээрээ утасны IP хаягийг мэдээд шууд компьютерээсээ хандаж орон тохиргоо хийх боломжтой.



3.3 IP хаягаа мэдэх


Утсандаа дугаар, нууц үгийнхээ тохиргоог хийхийн тулд web browser (Mozilla Firefox, Internet Explorer, Safari гэх мэт..) ашиглан IP хаягаар нь хандаж орох шаардлагатай. IP хаягаа мэдэхийн тулд:

Утасны нүүрэн талд байрлах *Menu* товчин дээр нэг дарна. Ингэснээр утасны цэс рүү орох ба *доошоо сумтай* ‘↓’ товчлуур дээр нэг дарахад **[2] IP Addr** гэсэн дэд цэс гарч ирэх болно. *Menu* товчоо дарж ороод гарч ирэх IP хаягийг тэмдэглэж авах хэрэгтэй. Жишээлбэл 192.168.005.106 хэлбэртэй тоо байна.




3.4 Дугаараа тохируулах

Browser-оо нээгээд address bar буюу хаяг бичдэг хэсэгт IP хаягаа бичээд Enter дарахад доорхи зурагт үзүүлсэн вэб хуудас гарч ирнэ. **Password** хэсэгт “admin” гэж оруулаад **Login** товчийг дарна.



Үүний дараа зурагт үзүүлсэн хуудас гарч ирэх бөгөөд дугаараа тохируулахын тулд **ACCOUNT** хэсэг рүү орно.



ACCOUNT хэсэг рүү ороход зурагт үзүүлсэн хуудас гарч ирэх ба дараах хэсгүүдийг бөглөнө.

Account Name: Компанийн нэр байж болно. Эсвэл хоосон орхиж болно.

SIP Server: Энэ хэсэгт серверийн 203.91.115.91 IP хаягийг бичиж өгнө.

SIP User ID: Энэ хэсэгт интернэтфон дугаараа оруулна.

Authenticate Password: Дугаартай хамт дагалдаж ирсэн нууц үгээ оруулна.

Name : Өөрийн нэрээ оруулж болно. Эсвэл хоосон орхиж болно.

The screenshot shows the 'Grandstream Device Configuration' web interface in Mozilla Firefox. The 'ACCOUNT' tab is selected, displaying various configuration fields for SIP account settings. The fields include:

- Account Name: G-Mobile (e.g., MyCompany)
- SIP Server: 203.91.115.91 (e.g., sip.mycompany.com, or IP address)
- Outbound Proxy: (e.g., proxy.myprovider.com, or IP address)
- SIP User ID: 98xxxxxx (the user part of an SIP address)
- Authenticate ID: (can be same or different from SIP UserID)
- Authenticate Password: (not displayed for security protection)
- Name: (optional, e.g., John Doe)
- Use DNS SRV: No Yes
- User ID is phone number: No Yes
- SIP Registration: No Yes
- Unregister On Reboot: No Yes
- Support SIP Instance ID: No Yes
- Register Expiration: 60 (in minutes. default 1 hour, max 45 days)
- local SIP port: 5060 (default 5060)
- SIP Registration Failure Retry Wait Time: 20 (in seconds. Between 1-3600, default is 20)
- SIP T1 Timeout: 1 sec

Тохиргоог хийсний дараагаар доод хэсэгт байрлах Update товчийг дарна.

The screenshot shows the 'SRTP Mode' and 'Special Feature' settings in the Grandstream Device Configuration web interface. The 'Update' button is highlighted with a red box.


choice 4: G.729A/B choice 8: GSM


SRTP Mode: Disabled Enabled but not forced
 Enabled and forced Optional

Special Feature: Standard

Update Cancel Reboot

Update дарсны дараа Reboot товч гарч ирэх ба үүн дээр дарснаар утас унтарч асаад тохиргоогоо авсан байх болно.



Ассаны дараагаар утасны дэлгэцний баруун дээд буланд  тэмдэг тогтмол байх юм бол таны дугаар амжилттай бүртгэгдсэн гэсэн үг бөгөөд мөн 311 руу залган шалгаж болно.

4. Factory Reset болон Firmware Upgrade хийх

Дээрх тохиргоонуудыг хийгээд таны дугаар хэвийн ажиллаж байвал эдгээр тохиргоог хийх шаардлагагүй юм. Харин санамсаргүйгээр өөр бусад тохиргоо өөрчилсөн, мөн огт бүртгэгдэхгүй байх зэрэг асуудлууд гарсан тохиолдолд эдгээр тохиргоог хийж үзэж болно.

4.1 Factory reset хийх

Factory reset гэдэг нь бүх тохиргоог үйлдвэрээс анх ирсэн төлөвт нь буцаах гэж ойлгож болно. Тиймээс таны өөрчилсөн тохиргоонууд бүгд арилна. Мөн таны өмнө тохируулсан дугаарын тохиргоо ч устах тул *Factory reset* хийсний дараа бүгдийг эхнээс нь дахин тохируулахыг анхаараарай.


- Утасны нүүрэн талд байрлах *Menu* товчин дээр дарж цэснүүдийг гаргаж ирнэ. Эндээс ‘↓’ товчлуурыг даран гүйлгэж “ -- rESEt --” цэсийг гаргаж ирнэ.
- Гаргаж ирсний дараа ямар ч товч дарахгүйгээр утасны ард байрлах MAC хаягийг оруулна. MAC хаяг гэдэг нь утасны ард цагаан цаасан наалтан дээр байрлах үсэг тоо холилдсон 12 оронтой тэмдэгт юм. (Жишээлбэл MAC 000B821F36ED гэх мэт..) Үүнийг утасны товчлууруудыг ашиглан гар утсаар мессеж бичдэгтэй адилхан зарчмаар оруулна. (Жишээлбэл а үсэг гаргахын тулд 2-ын тоон дээр 2 удаа хурдан дарна)
- MAC-аа оруулаад *Menu* товчин дээр дарснаар утас *Restart* хийж бүх тохиргоо үйлдвэрээс ирсэн тохиргоондоо орно.
- Өмнө дурдсан зааврын дагуу дугаараа тохируулна.

4.2 Firmware upgrade хийх

Firmware upgrade хийснээр таны утас програмын хувьд дахин шинэ хувилбартай болно гэсэн үг юм. Зарим тохиолдолд таны ашиглаж байгаа сүлжээний онцлог, нөхцөл байдлаас хамааран хуучин хувилбарууд нь ажиллахгүй байх тал бий.

1. HTTP server-ээс firmware update хийх

- Grandstream-ээс сүүлд гаргасан update-уудын жагсаалтыг <http://www.grandstream.com/firmware.html> (Зураг-2) хаягаас харж болно



BACK MAIN

Firmware Updates

Firmware for all Grandstream products are improved and updated on a regular basis. Please check for the latest upgrade for your product or sign up to receive newsletter for new/beta firmware releases.
Grandstream recommends using HTTP protocol for firmware upgrades. **Please note we have switched our public firmware upgrade server to use HTTP.**


Current Official Firmware

Product	Firmware Version	Release Note	HTTP Server	Beta Test Firmware
Handytone Series				
HT286 (Rev. 2.0)	1.0.7.19	1.1.0.45	72.172.83.110	
HT286 (Rev. 3.0)	1.1.0.45	1.1.0.45	72.172.83.110	
HT502	1.0.1.63	1.0.1.63	72.172.83.110	1.0.3.10 ^{BETA}
HT503	1.0.1.63	1.0.1.63	72.172.83.110	1.0.3.10 ^{BETA}
IP Phones				
BudgeTone 200/201	1.2.4.3	1.2.4.3	72.172.83.110	1.2.5.2 ^{BETA}

Зураг-2


BT200-д зориулсан version-ыг сонгоод HTTP server-ын IP хаягийг утасан дээрээ тохируулна.

- BT200 дээр Зураг-3 үзүүлсэнээр тохиргоо хийнэ




Зураг-3

- Тохиргоо хийсэний дараа UPDATE (Зураг-4) товчийг дарж хадгалаад REBOOT хийнэ.



Зураг-4

Reboot хийгдэж дуусаны дараа software version update хийгдсэнийг шалгана (Зураг-5).



Зураг-5

IP утасны Software version нь <http://www.grandstream.com/firmware.html> хуудас дээрх BT200-ийн firmware version-той тохирч байх ёстой.

2. TFTP firmware update хийх

- <http://www.grandstream.com/firmware.html> (Зураг-6) хаяг руу орж BT200 version-ийг татаж авна. Татаж авсан файл хэрэв zip file бол WinRAR болон бусад программ ашиглаж задлах хэрэгтэй.

The screenshot shows the Grandstream website's 'Firmware Updates' page. A 'Download File' dialog box is open, displaying the file 'Release_BT200_GXP_1.2.4.3.zip' which is a WinRAR ZIP archive. The 'Save File' option is selected, and the 'OK' button is highlighted with a red box. Below the dialog, the 'Current Official Firmware' table is visible, with the '1.2.4.3' version for the 'Budgetone 200/201' product highlighted with a red box.

Product	Firmware Version	Release Note		
Handytone Series				
HT286 (Rev. 2.0)	1.0.7.19	1.1.0.45		
HT286 (Rev. 3.0)	1.1.0.45	1.1.0.45	72.172.83.110	
HT502	1.0.1.63	1.0.1.63	72.172.83.110	1.0.3.10 BETA
HT503	1.0.1.63	1.0.1.63	72.172.83.110	1.0.3.10 BETA
IP Phones				
Budgetone 200/201	1.2.4.3	1.2.4.3	N/A	1.2.5.2 BETA


Зураг-6

- TFTP server (Cisco TFTP, бусад tftp server байж болно)–ээ компьютер дээрээ интернетээс татаж суулгана. Бид энэ тохиолдолд Cisco TFTP server-ыг ашигласан. Зураг-7-д үзүүлсэнээр татаж авсан version файлынхаа замыг **VIEW** цэснээс **OPTIONS**→**TFTP server root directory**→**Browser** дээр дарж зааж өгнө.

The screenshot shows a file browser window with two dialog boxes open. The 'Options' dialog box has 'Show file transfer progress' and 'Enable logging' checked. The 'Browse for TFTP Server Root Directory' dialog box shows a file tree with 'Release_BT200_GXP_1.2.4.3' selected, highlighted with a red box.

Зураг-7

BT200 дээрээ TFTP-ээс update хийх тохиргоог хийнэ. Үүний тулд TFTP server-ын IP хаягийг мэдэж байх хэрэгтэй (ерөнхийдөө tftp server ажилж байгаа компьютерын хаяг байдаг). Жнь **Зураг-8** дээр TFTP server хаягийг нь харуулсан байна.



Зураг-8

- BT200 дээрх тохиргоо хийсэн байдал

A screenshot of the "Grandstream Device Configuration" web interface. The "ADVANCED SETTINGS" tab is selected. The configuration includes fields for Admin Password, G723 rate (6.3kbps encoding rate selected), iLBC frame size (20ms selected), iLBC payload type (97), Silence Suppression (No selected), Voice Frames per TX (2), Layer 3 QoS (48), Layer 2 QoS (802.1Q/VLAN Tag 0, 802.1p priority value 0), Data VLAN Tag (1: 0, 2: 0, 3: 0), No Key Entry Timeout (4), Use # as Dial Key (Yes selected), local RTP port (5004), Use random port (No selected), keep-alive interval (20), Use NAT IP, STUN server, Firmware Upgrade and Provisioning (Upgrade Via TFTP selected), Firmware Server Path (192.168.5.63), Config Server Path (192.168.5.63), and Firmware File Prefix.

- UPDATE (Зураг-4) товчийг дарж хадгалаад REBOOT хийнэ.
- Reboot хийгдэж дуусаны дараа software version update (Зураг-5) хийгдсэнийг шалгана.

Хэрвээ танд ямар нэгэн асуудал гарвал 98102000 дугаар болон gnetphone@yahoo.com мессенжерийн хаягт холбогдоно уу. /24 цаг/